

1. "Захиргааны байгууллага" гэдэгт юуг ойлгох вэ?

Нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн засагласан шийдвэр гаргадаг, торийн гvйцэтгэх эрх мэдлийг хэрэгжvүлдэг тов, орон нутгийн бvх байгууллага, тvvнчлэн Засгийн газрын байгууллагын зарим vүргийг толоолон гvйцэтгэдэг Засгийн газрын бус байгууллага, хууль болон нийтийн эрх зvйн гэрээний vндсэн дээр бусдыг захирамжилсан шийдвэр гаргаж, нийтлэг вйлчилгээ vзvүлдэг сургууль, эмнэлэг, холбоо, харилцаа, эрчим хvчний зэрэг байгууллагын захиргаа, нутгийн оороо удирдах ёсны болон шашны байгууллага зэрэг нийтийн эрх зvйн субъект болох байгууллагыг хамруулан ойлгоно.

2. "Захиргааны албан тушаалтан" гэж хэн бэ?

Энэ нь Нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн засагласан шийдвэр гаргадаг, торийн гvйцэтгэх эрх мэдлийг хэрэгжvүлдэг тов, орон нутгийн бvх байгууллага, тvvнчлэн Засгийн газрын байгууллагын зарим vүргийг толоолон гvйцэтгэдэг Засгийн газрын бус байгууллага, хууль болон нийтийн эрх зvйн гэрээний vндсэн дээр бусдыг захирамжилсан шийдвэр гаргаж, нийтлэг вйлчилгээ vзvүлдэг сургууль, эмнэлэг, холбоо, харилцаа, эрчим хvчний зэрэг байгууллагын захиргаа, нутгийн оороо удирдах ёсны болон шашны байгууллага зэрэг нийтийн эрх зvйн субъект болох байгууллагын нийтийн эрх зvйн хvрээнд захирамжлах, зохион байгуулах бvрэн эрхийг бие даан хэрэгжvүлдэг торийн жинхэнэ албан хаагч, тvvнчлэн нийтийн эрх зvйн холбогдолтой асуудлаар бусдыг захирамжилсан шийдвэр гаргадаг торийн бус албан тушаалтан юм.

3. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь "иргэн" гэдэгт хэнийг хамруулан vздэг вэ?

vүнд Монгол Улсын иргэн, гадаад улсын иргэн, харьяалалгvй хvнийг хамруулна.

4. "Захиргааны акт" гэж юу вэ?

Нийтийн эрх зvйн хvрээнд vүссэн тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар захиргааны байгууллага, албан тушаалтнаас амаар буюу бичгээр гаргасан захирамжилсан шийдвэр болон эрх зvйн vр дагавар шууд бий болгодог нэг удаагийн захирамжилсан бусад арга хэмжээ /вйлдэл, эс вйлдэхvй/ болон захиргааны байгууллагын хэм хэмжээ тогтоосон шийдвэр /зарлиг, тогтоол, дvрэм, заавар, журам/-ийг захиргааны актад хамааруулна.

5. "Эс вйлдэхвй" гэдэгт юуг ойлгох вэ?

Иргэн, хуулийн этгээдээс эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хэрэгжvvлэх, хамгаалуулахаар гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх вvргээ захиргааны байгууллага, албан тушаалтнаас хуульд заасан хугацаанд биелvvлээгвй буюу шийдвэрлэхгвй орхигдуулсныг ойлгоно.

6. "Нэхэмжлэл" гэж юуг хэлэх вэ?

Иргэн, хуулийн этгээдээс захиргааны хууль бус актын улмаас зорчигдсон эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар захиргааны хэргийн шvvхэд хандаж гаргасан оргодлийг хэлнэ.

7. "Гомдол" гэж юуг хэлэх вэ?

Захиргааны хууль бус актын талаар тухайн байгууллагын удирдах дээд шатны нь байгууллага, албан тушаалтанд болон шvvхэд хандаж гаргасан нэхэмжлэлээс бусад оргодлийг хэлнэ.

8. Захиргааны хэргийн шvvхийн хянан шийдвэрлэх маргаанд юуг багтаах вэ?

Монгол Улсын Засгийн газрын гишvvн /Еронхий сайд, сайд/, Монгол Улсын яам, Монгол Улсын Засгийн газрын тохируулагч болон хэрэгжvvлэгч агентлаг, Торийн албаны Зовлол, тvvний салбар байгууллага, Монголбанк, Санхvvгийн зохицуулах хороо, яамны харьяа болон харьяа бус захиргааны акт гаргадаг бие даасан агентлаг, тvvнтэй адилтгах газар, зовлол, товчоо, тов, сан зэрэг байгууллага, аймаг, нийслэл, сум, дvvрэг, баг, хорооны Засаг дарга, аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх тохируулагч болон хэрэгжvvлэгч агентлаг /хэлтэс, газар/, улсын хяналт шалгалтын болон захиргааны хяналтын байгууллага, тэдгээрийн хянан шалгагч, байцаагч, цагдаагийн, тагнуулын, хилийн цэргийн байгууллага, тvvний захиргааны таслан зогсоох болон шийтгэлийн арга хэмжээ авах эрх бvхий бvх албан тушаалтан, аймаг, нийслэл, сум, дvvргийн иргэдийн Толоологчдийн Хурал, баг, хорооны иргэдийн нийтийн Хурал, тэдгээрийн Тэргvvлэгчид, торийн ба холимог омчийн сургууль, эмнэлэг болон холбоо, харилцаа, эрчим хvчний системийн захиргаа зэрэг вйлчилгээг нь нийтээс заавал хэрэглэдэг байгууллага, сvм хийдийн захиргаа, шийдвэр, вйл ажиллагааг нь захиргааны хэргийн шvvхэд давж гомдол гаргаж байхаар хуульд тусгайлан заасан нийтийн эрх зvйн субъект болох бусад байгууллага, албан тушаалтны зовхон гадагш /бусдаас/ дагаж мордох буюу заавал биелvvлэх захиргааны акт нь захиргааны хэргийн шvvхэд хамаарна.

Харин шvvх, прокурорын байгууллага, тvvнчлэн эрvvгийн хэрэг бvртгэх, мордон байцаах болон шvvхийн шийдвэр гvйцэтгэх байгууллагын байцаан шийтгэх, эсхvл Шvvхийн шийдвэр гvйцэтгэх тухай хуулийн дагуу явуулсан вйл ажиллагааны талаар иргэн, хуулийн этгээдээс шvvхэд гаргасан гомдлыг эрvvгийн болон иргэний хэргийн шvvх хянан шийдвэрлэнэ.

9. Захиргааны хэргийн шvvхэд нэхэмжлэл гаргах эрх хэдийд vvcэх вэ?

Иргэн, хуулийн этгээд дараахь тохиолдолд захиргааны хэргийн шvvхэд нэхэмжлэл гаргах эрхтэй:

- 1.хуульд тусгайлан заасан;
 - 2.дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтнаас Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8 дугаар зvйлд заасан журмын дагуу гаргасан шийдвэрийг эс зовшоорсон;
 - 3.захиргааны байгууллага, албан тушаалтан Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8 дугаар зvйлд заасан журмын дагуу гаргасан шийдвэрийг биелvvлээгvй;
 - 4.шууд харьяалах дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан гомдлыг хуульд заасан хугацаанд хянан шийдвэрлээгvй.
- Tvvнчлэн харьяалах дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан байхгvй бол иргэн, хуулийн этгээд нь зорчигдсон эрхээ хамгаалуулахаар захиргааны байгууллага, албан тушаалтны захиргааны хууль бус акт нь тvvний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зорчсон гэж vзвэл холбогдох захиргааны актыг хvlээн авснаас, эсхvl мэдсэнээс хойш 30 хоногийн дотор захиргааны хэргийн шvvхэд нэхэмжлэл гаргана.

10. Захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа гэж юу вэ?

Иргэн захиргааны хэргийн шvvхэд хандахаас омно тухайн захиргааны байгууллага, албан тушаалтныг харьяалах дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан байхгvйгээс бусад тохиолдолд заавал урьдчилан шийдвэрлэх ажиллагаа хийлгэсэн байх ёстой. Оороор хэлбэл дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гомдол гаргасан байна.

Ингэхдээ хуульд оороор заагаагvй бол иргэн, хуулийн этгээд захиргааны байгууллага, албан тушаалтны захиргааны хууль бус акт нь тvvний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зорчсон гэж vзвэл холбогдох захиргааны актыг хvlээн авснаас, эсхvl мэдсэнээс хойш 30 хоногийн дотор тухайн байгууллага, албан тушаалтныг шууд харьяалах дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд гомдлоо гаргана. Харин дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан нь иргэн, хуулийн этгээдээс гаргасан гомдлыг Иргэдээс торийн байгууллага, албан тушаалтанд гаргасан оргодол, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хvlээн авч хуульд оороор заагаагvй бол 30 хоногийн дотор хянан шийдвэрлэж хариу огно. Шаардлагатай тохиолдолд уг хугацааг байгууллагын удирдах албан тушаалтан 30 хvртэл хоногоор сунгаж болно. Хугацаа сунгасан тухай гомдол гаргасан иргэн, хуулийн этгээдэд мэдэгдэнэ.

11. Захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх журам нь ямар байдаг вэ?

Дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан гомдлыг урьдчилан шийдвэрлэх талаар дараахь ажиллагаа явуулна:

- 1.захиргааны акт хууль тогтоомжид нийцсэн эсэхийг шалгах;

2.гомдол гаргагч, тvvний толоологч, омгоологч, шаардлагатай бол эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хондогдсон гуравдагч этгээдэд хэрэг шийдвэрлэх он, сар, одор, газрыг мэдэгдэж, уг ажиллагаанд хvсэлтээр нь байлцуулах. Хэрэв эдгээр этгээд хvрэлцэн ирээгvй бол тэдгээрийн оролцоогvйгээр хэргийг урьдчилан шийдвэрлэж болно.

3.Шаардлагатай гэж vзвэл шинжээч томилон дvгнэлт гаргуулна.

4.Урьдчилан шийдвэрлэх ажиллагааны явцын талаар тэмдэглэл хотлох бoгоод тvvнд шийдвэр гаргаж байгаа байгууллагын нэр, хаяг, албан тушаалтны овог, эцгийн болон оорийн нэр; шийдвэр гаргасан, хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа явуулсан он, сар, одор, газар; гомдол гаргагч, хариуцагч, бусад оролцогчын овог, эцгийн болон оорийн нэр; гомдлын агуулга, шаардлага; шинжээчийн дvгнэлт, гэрчийн мэдvvлэг бусад нотлох баримт; тэмдэглэл хотолсон болон гомдлыг шийдвэрлэсэн албан тушаалтан, захиргааны байгууллагын эрх баригчийн гарын vсгийг тусгана.

Хамтын удирдлага бvхий захиргааны байгууллага гомдлыг хэлэлцсэн бол асуудал шийдвэрлэх ердийн журмыг баримтлан шийдвэр гаргана. Гомдлыг хvlээж авсан байгууллага, албан тушаалтан маргаантай захиргааны актын биелэлтийг гомдол бvхий хэргийг хянан шийдвэрлэх хvртэл тvдгэлзvvлж болно.

12. Дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан гомдлыг хянан vзээд ямар шийдвэр гаргах вэ?

1.захиргааны акт илт хууль бус болохыг хvlээн зовшоорох;

2.маргаан бvхий захиргааны акт нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зорчсон бол уг захиргааны актыг бvхэлд нь, эсхvл холбогдох хэсгийг хvчингvй болгох;

3.захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус эс вйлдэхvй нь иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зорчсон бол захиргааны зохих акт гаргахыг тухайн захиргааны байгууллага, албан тушаалтанд даалгах шийдвэрийн аль нэгийг гаргана.

Энэхvv дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэрийг холбогдох захиргааны байгууллага, албан тушаалтан заавал биелvvлнэ.

13. Дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан ямар тохиолодолд захиргааны акт илт хууль бус болохыг хvlээн зөвшөөрсөн шийдвэр гаргах вэ?

1.захиргааны акт утга агуулгын илэрхий алдаатай;

2.бичгийн хэлбэрээр гаргасан захиргааны актыг батлан гаргасан байгууллага, албан тушаалтан нь тодорхойгvй;

3.захиргааны акт гаргах эрх хэмжээгvй захиргааны байгууллага, албан тушаалтан гаргасан;

4.захиргааны актыг гvйцэтгэх субъект тодорхой бус;

5.хууль бус вйлдэл, эс вйлдэхvйг гvйцэтгэхийг шаардсан;

6.нийтийн ёс зvйн хэм хэмжээг илт зорчсон;

7.захиргааны акт гаргах эрх зvйн vндэслэл байгаагvй;

8.захиргааны акт гаргах хуульд заасан хоон хэлэлцэх хугацаа онгорсон;

9.захиргааны акт оор бусад байдлаар холбогдох хууль зорчсон тохиолдолд захиргааны

актыг илт хууль бус болохыг хвлээн зовшоорсон шийдвэр гаргана.

Тvvнчлэн захиргааны актын аль нэг заалт илт хууль бус богоод тухайн заалтгвйгээр захиргааны актын агуулга ойлгомжгвй болоход хврвэл захиргааны актыг бvхэлд нь илт хууль бус гэж тооцно.

14. Дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан ямар тохиолдолд маргаан бvхий захиргааны актыг хvчингвй болгох вэ?

Маргаан бvхий захиргааны акт иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зорчсон нь тогтоогдсон бол дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан уг актыг хvчин тоголдор вйлчилж байгаа, эсхвл ирээдвйд хvчин тоголдор болох эсэхээс вл хамааран бvхэлд нь буюу холбогдох хэсгийг хvчингвй болгосон шийдвэр гаргана.

15. Дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан ямар тохиолдолд захиргааны акт гаргахыг даалгах шийдвэр гаргах вэ?

1. захиргааны акт гаргахаас vндэслэлгвйгээр татгалзсан шийдвэр байгаа бол тvvнийг хvчингвй болгож, захиргааны акт гаргах;

2. захиргааны байгууллага, албан тушаалтны эс вйлдэхвйн улмаас иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зорчигдсон нь тогтоогдсон бол дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан захиргааны зохих акт гаргахыг тухайн захиргааны байгууллага, албан тушаалтанд даалгана.

Тvvнчлэн захиргааны байгууллага, албан тушаалтан дээр дурдснаас бусад вйлдэл хийж гвйцэтгэхийг даалгасан шийдвэр гаргаж болно.

16. Захиргааны хэргийн шvvх захиргааны хэрэг хянан шийдвэрлэхдээ ямар зарчим баримтлах вэ?

1. Шvvхийн омно эрх тэгш байх
2. Шvvх эрх мэдлийг шvvх хэрэгжvvлэх, шvvгч хараат бус байх
3. Мэтгэлцэх зарчим
4. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах хэл, бичиг
5. Шvvх хуралдааныг нээлттэй явуулах
6. Шvvх хуралдааныг тасралтгвй явуулах
7. Хууль, олон улсын эрх зvйн хэм хэмжээг хэрэглэх
8. Шvvхийн шийдвэр заавал биелэгдэх

17. Захиргааны хэргийн нутаг дэвсгэрийн харьяалал гэдэгт юуг ойлгох вэ?

Энэ нь нэхэмжлэлийг тухайн шийдвэр гаргасан захиргааны байгууллага, албан тушаалтны оршин байгаа газрын захиргааны хэргийн шvvхэд гаргах явдал мон.

18. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх шvvхийн харьяалал ямар байдаг вэ?

Аймаг, нийслэлийн захиргааны хэргийн шvvх энэ хуульд заасны дагуу vvcгэсэн захиргааны хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ.

Улсын дээд шvvхийн захиргааны хэргийн танхим:

1. аймаг, нийслэлийн захиргааны хэргийн шvvх анхан шатны журмаар шийдвэрлэсэн хэргийг давж заалдах шатны журмаар;

2. Улсын дээд шvvхийн захиргааны хэргийн танхим давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэсэн болон анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн шvvхийн хvчин тоголдор шийдвэртэй хэргийг хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэнэ.

Монгол Улсын дээд шvvх шаардлагатай гэж vзвэл ямар ч хэргийг татан авч анхан шатны журмаар хянан шийдвэрлэх эрхтэй.

19. Захиргааны хэргийн оролцогч гэдэгт хэнийг ойлгох вэ?

Нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийг хэргийн оролцогч гэнэ. Харин нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийн толоологч буюу омгоологч нь захиргааны хэргийн бие даасан оролцогч бус зовхон толоолvvлж буюу омгоолvvлж байгаа этгээдийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг илэрхийлэн хамгаалж буй этгээд байдаг.

20. Нэхэмжлэгч гэж хэнийг хэлэх вэ?

Захиргааны хууль бус актын улмаас зорчигдсон эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар захиргааны хэргийн шvvхэд мэдvvлэн нэхэмжлэл гаргаж байгаа иргэн, хуулийн этгээдийг нэхэмжлэгч гэнэ.

21. Захиргааны хэргийн шvvхэд нэхэмжлэл гаргахад эрх зvйн чадвар, чадамжтай байх явдлыг юу гэж ойлгох вэ?

Иргэний эрх зvйн чадвар нь иргэнийг торсон veэс эхэлж нас барснаар дуусгавар болно. Иргэний эрх зvйн чадвар гэдэгт иргэн эрх зvйн харилцаанд оролцож эрх эдэлж, vvpрэг хvlээх еронхий боломжийг ойлгох богоод бvх иргэд энэ боломжийг тэгш эдэлнэ. Иргэний эрх зvйн чадварыг хязгаарлахыг хориглоно. Захиргааны хэргийг захиргааны хэргийн шvvхэд хянан шийдвэрлэхэд иргэн, хуулийн этгээд оролцох эрхтэй. Хуулийн этгээдийн эрхгvй боловч тухайн захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд зайлшгvй шаардлагатай холбоо, сан зэрэг нэгтгэлийг шvvгч захирамж гаргаж уг захиргааны хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд татан оролцуулж болно.

Харин иргэний эрх зvйн чадамж гэдэг бол иргэн оорийн vйлдлээр оортоо эрх олж авах, vvpрэг бий болгох чадвар юм. Иргэний эрх зvйн бvрэн чадамж насанд хvрснээр буюу 18 наснаас бий болно. Шvvх 16-аас 18 хvртэлх насны иргэнийг зохих журмын дагуу иргэний эрх зvйн бvрэн чадамжтай гэж тооцож болно. Захиргааны хэргийн шvvхэд захиргааны эрх зvйн хэм хэмжээгээр заагдсан эрхээ оороо хэрэгжvvлж vvpргээ

биелvvлэх, хариуцлага хvlлээх буюу толоологчоороо гvйцэтгvvлэх чадварыг иргэний эрх зvйн бvрэн чадамжтай этгээд эдэлнэ.

Иргэний эрх зvйн зарим чадамжтай, эсхvл сэтгэцийн овчний, мансууруулах бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэдэгийн улмаас эрх зvйн чадамжгvй гэж тооцогдсон хvний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг тvvний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч толоолон хамгаалана.

Хуулийн этгээдийн эрх зvйн чадвар улсын бvртгэлд бvртгvvлснээр vvсч, хуульд заасан журмын дагуу татан буугдаж улсын бvртгэлээс хасагдсанаар дуусгавар болно.

22. Хариуцагч гэж хэнийг хэлэх вэ?

Захиргааны хууль бус акт гаргаж, нэхэмжлэгчийн эрх, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг зорчсон гэж нэхэмжлэлд дурдсан захиргааны байгууллага, албан тушаалтныг хариуцагч гэнэ.

23. Гуравдагч этгээд гэж хэнийг хэлэх вэ?

Бусад иргэн, хуулийн этгээдээс гаргасан нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийн шvvх дээр vvсгэсэн захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оорийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалан захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах нь зvйтэй гэж захиргааны хэргийн шvvх шийдвэрлэсэн иргэн, хуулийн этгээдийг хэлнэ. Гуравдагч этгээдийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох байдлаар нь бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд, бие даасан шаардлага гаргаагvй гуравдагч этгээд гэж хоёр хэсэгт хуваан vздэг.

Гуравдагч этгээд нь нэхэмжлэгч, хариуцагчийн нэгэн адил эрх эдэлж, vvрэг хvlээнэ.

24. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгч ямар эрх, vvрэгтэй оролцох вэ?

Нэхэмжлэгч захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо:

- 1.нэхэмжлэлээ оорчлох, тvvний шаардлагын хэмжээг ихэсгэх буюу багасгах, нэхэмжлэлээсээ татгалзах, хариуцагчтай эвлэрэх;
- 2.захиргааны хэргийн шvvхийн болон эсрэг талын шаардлага, тайлбар, нотлох баримт, хэргийн материалтай танилцах, тvvнээс тэмдэглэл, хуулбар хийх, тэдгээрт тайлбар огох, шvvх хуралдаанд оролцох;
- 3.нотлох баримт гаргаж огох, гэрчээс мэдvvлэг авахуулах, шинжээч томилуулах, бусад нотлох баримт цуглуулах, шvvх хуралдааныг хуульд заасан vндэслэлээр хойшлуулах тухай хvсэлт гаргах;
- 4.шvvх бvрэлдэхvн буюу шvvгч, прокурор, иргэдийн толоологч, шvvх хуралдааны нарийн бичгийн дарга, шинжээч, орчуулагч, хэлмэрчийг хуульд заасан vндэслэлээр татгалзан гаргахыг шаардах;
- 5.шvvх хуралдааны бусад оролцогчид асуулт тавих;
- 6.захиргааны хэргийн шvvхийн шийдвэрийг давж заалдах, эсхvл хяналтын журмаар

гомдол гаргах;

7. хуульд заасан бусад эрх эдэлнэ.

Нэхэмжлэгч захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо:

1.захиргааны хэргийн шvvхийн дуудсанаар хврэлцэн ирэх;

2.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам, шvvх хуралдааны дэгийг сахих;

3.захиргааны хэргийн шvvхийн тавьсан шаардлага, шийдвэрийг биелvvлэх vvpрэг хвлээнэ.

25. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хариуцагч ямар эрх, vvpрэгтэй оролцох вэ?

Хариуцагч захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо дараахь эрх эдэлнэ:

1.захиргааны хэргийн шvvхийн дуудсанаар хврэлцэн ирэх;

2.нэхэмжлэлийн шаардлагыг хвлээн зовшоорох, биелvvлэх, эсхвл татгалзах, сорог нэхэмжлэл гаргах, нэхэмжлэгчтэй эвлэрэх;

3.захиргааны хэргийн шvvхийн болон эсрэг талын шаардлага, тайлбар, нотлох баримт, хэргийн материалтай танилцах, тvvнээс тэмдэглэл, хуулбар хийх;

4. гэрчээс мэдvvлэг авахуулах, шинжээч томилуулах, нэмэлт нотлох баримт цуглуулах, шvvх хуралдааныг хуульд заасан vндэслэлээр хойшлуулах тухай хвсэлт гаргах;

5. шvvх бvрэлдэхvvн буюу шvvгч, прокурор, иргэдийн толоологч, шvvх хуралдааны нарийн бичгийн дарга, шинжээч, орчуулагч, хэлмэрчийг хуульд заасан vндэслэлээр татгалзан гаргахыг шаардах;

6. шvvх хуралдааны бусад оролцогчид асуулт тавих;

7. захиргааны хэргийн шvvхийн шийдвэрийг давж заалдах, эсхвл хяналтын журмаар гомдол гаргах;

8. хуульд заасан бусад эрх эдэлнэ.

Хариуцагч захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо:

1.нэхэмжлэлийн талаар бичгээр тайлбар гаргах, захиргааны хэргийн шvvхээс шаардсан нотлох баримтыг гаргаж огох;

2. захиргааны хэргийн шvvхээс тавьсан шаардлага, шийдвэрийг биелvvлэх, шvvх хуралдаанд оролцох;

3.захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам, шvvх хуралдааны дэгийг сахих, захиргааны хэргийн шvvхийн шийдвэрийг биелvvлэх vvpрэг хвлээнэ.

26. Захиргааны хэргийн шvvхэд хэд хэдэн этгээд хамтран нэхэмжлэл гаргаж болох уу?

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэгэн адил шаардлага бvхий нэхэмжлэлийг хэд хэдэн нэхэмжлэгч хамтран гаргаж болно. Энэ тохиолдолд нэхэмжлэгчид дундаасаа толоологч томилон итгэмжлэл буюу бvрэн эрх олгож, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оорсдийгоо толоолvvлэн оролцуулах эрхтэй. Нэхэмжлэлийг 20 буюу тvvнээс дээш этгээд хамтран гаргасан тохиолдолд шvvгч тэдэнд толоологчоо захиргааны хэрэг vvcгэснээс хойш 14 хоногийн дотор томилон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулахыг санал болгоно. Энэ

хугацаанд нэхэмжлэгчид толоологчоо томилоогvй бол шvvгч тэдний дундаас толоологчийг нь томилно. Толоологчийн тоо 3-аас илvvгvй байх ба энэ тохиолдолд шvvгч толоологчийн бvрэн эрхийг хязгаарлаж болохгvй.

27. Нэг нэхэмжлэлд хэд хэдэн хариуцагч байгаа тохиолдолд яах вэ?

Нэг нэхэмжлэлд хэд хэдэн хариуцагч байж болох ба тэдгээр нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бие даан оролцох эрхтэй. Хамтран хариуцагчид нь ашиг сонирхлын зорчилгvй, уг хэргийг хянан шийдвэрлэхэд бvгд оролцох шаардлагагvй, тvvнчлэн хэргийн шийдвэрт соргоор нолоолохгvй гэж vзвэл хэн нэгийгээ томилон оорсдийгоо толоолvvлэн оролцуулж болно.

28. Хариуцагчаар татагдсан этгээд уг нэхэмжлэлийн жинхэнэ хариуцагч биш байвал ямар ажиллагаа хийгдэх вэ?

Хариуцагчаар татагдсан этгээд уг нэхэмжлэлийн жинхэнэ хариуцагч биш болох нь нотлох баримтаар тогтоогдвол тvvнийг шvvгч нэхэмжлэгчийн зовшоорсноор жинхэнэ хариуцагчаар солино. Хариуцагчийг солихыг нэхэмжлэгч зовшоороогvй бол уг этгээдийг шvvгч хамтран хариуцагчаар татан оролцуулна. Хариуцагчийг нотлох баримт цуглуулахаас омно солих богоод хэрэв тийнхvv цуглуулсны дараа солиход хvрвэл шинээр тогтоогдсон хариуцагч буюу хамтран хариуцагч уг хэргийн нотлох баримтыг шинээр цуглуулж vнэлvvлэхийг шаардах эрхтэй.

29. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх залгамжлан авч болох уу?

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчийн эрхийг залгамжлан авч болно.

Эрх залгамжлан авах гэдэгт маргаантай эрх зvйн харилцааны нэхэмжлэгч, хариуцагчийн аль нэг нь уг эрх зvйн маргаанаас гарсан /хvн нас барсан, сураггvй алга болсонд тооцогдсон, хуулийн этгээд татан буугдсан, шаардлага ба vvpгээ бусдад шилжvvлсэн/ бол шvvх тэрхvv нэхэмжлэгч, хариуцагчийг сонирхогч этгээд буюу эрх залгамжлагчийн гаргасан хvсэлтээрэрх залгамжлан авбал зохих этгээдээр сольж болно. Эрх залгамжлан авах явдал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч шатанд гvйцэтгэгдэж болно. Эрх залгамжлагч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас гарсан этгээдийн бvх эрхийг эдэлж, vvpргийг хvлээнэ.

30. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэн, хуулийн этгээдийг төлөөлж болох уу?

Иргэний эрх зvйн чадамж бvхий иргэн мэргэжлийн хувьд шаардлагатай гэж vзвэл хяналтын шатны шvvхэд захиргааны хэргийг хянан хэлэлцэхэд толоологчоо оролцуулна.

Хууль, эрх зvйн бусад акт болон vvcгэн байгуулах баримт бичгийн дагуу олгогдсон эрх хэмжээний хvрээнд байгууллагын эрх баригч, эсхvл тvvний итгэмжлэгдсэн толоологч нь захиргааны хэргийн шvvхийн хянан шийдвэрлэх ажиллагаанд хуулийн этгээдийг толоолно. Захиргааны хэргийн шvvхийн хянан шийдвэрлэх ажиллагаанд хуулийн этгээдийн толоологчоор оролцох байгууллагын эрх баригч нь оорийн албан тушаал, эрх хэмжээгээ гэрчилсэн баримт бичиг, бусад ажилтан олгогдсон итгэмжлэлээ захиргааны хэргийн шvvхэд vзvvлнэ.

Бичгээр олгосон итгэмжлэл нь:

- 1.итгэмжлэлд толоолvvлэгч гарын vсэг зурсан байх, хуулийн этгээдийн итгэмжлэлд эрх баригч гарын vсэг зурж, тамга, тэмдэг дарсан байх;
- 2.хуулийн этгээдийн эд хоронгийг хvлээн авах, бусдад шилжvvлэх, захиран зарцуулах эрх олгосон итгэмжлэлд эрх баригчаас гадна нягтлан бодогч гарын vсэг зурсан байх;
3. олгосон он, сар, одрийг заах;
- 4.хуульд заасан бол нотариатаар гэрчлvvлэх;
5. итгэмжлэлийг тодорхой хугацаагаар олгох бол хугацааг заах шаардлагыг хангасан байвал зохино.

31. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь иргэн, хуулийн этгээдийн төлөөлөгчийн ямар бvрэн эрхтэй байдаг вэ?

Толоологч нь толоолvvлж буй этгээдийн эрх, эрх чолоо, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хамгаалах вйл ажиллагааг хуулийн хvрээнд явуулна.

Толоологч нь толоолvvлж буй этгээдээс олгосон итгэмжлэлд тусгайлан заасан тохиолдолд:

1. нэхэмжлэлийн оргодолд гарын vсэг зурах;
2. нэхэмжлэлийг хvлээн авах;
- 3.нэхэмжлэлийн шаардлагаас бvрэн буюу хэсэгчлэн татгалзах;
- 4.нэхэмжлэлийн шаардлагыг оорчлох;
- 5.эвлэрэх;
- 6.захиргааны хэргийн шvvхийн шийдвэрийг давж заалдах, эсхvл хяналтын журмаар гомдол гаргах;
- 7.толоолvvлэгчээс олгосон итгэмжлэлийг бусдад шилжvvлэх;
- 8.захиргааны хэргийн шvvхийн шийдвэрийг албадан биелvvлэхийг шаардах эрх эдэлнэ.

32. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэн, хуулийн этгээдийг хэн төлөөлөн оролцож болохгvй вэ?

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэн, хуулийн этгээдийг 18 насанд хvрээгvй болон эрх зvйн зарим буюу бvрэн чадамжгvй этгээд толоолон оролцож болохгvй. Тvvнчлэн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хувиар, эсхvл ажиллаж байгаа байгууллагаа толоолон тухайн захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаагаас бусад тохиолдолд шvvгч, прокурор, хэрэг бvртгэгч, мордон байцаагч толоолон оролцож болохгvй.

33. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч хэрхэн оролцох вэ?

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд омгоологч гэрээний vндсэн дээр нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийг толоолон оролцож болно. Талууд захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч ve шатанд омгоологчийн туслалцаа авч болно. Тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох омгоологчийн бvрэн эрх нь хууль зvйн туслалцаа авч байгаа талын хvсэлтээр тодорхойлогдоно. Омгоологч нь захиргааны хэрэг хянан хэлэлцэхэд гэрээгээр оролцохдоо Омгооллийн тухай хуульд заасан эрх эдэлж, vврэг хvлээнэ.

34. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь нотлох баримт гэж юу вэ?

Хэргийн оролцогчоос оорийн шаардлага ба татгалзлаа vндэслэж байгаа, шvvх хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бvхий, хуульд заасан арга хэрэгслээр олж авсан бодитнохцол байдлыг тогтооход шаардлагатай аливаа баримтат мэдээллийг нотлох баримт гэнэ. Хэргийн нотлох баримт нь нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд, тэдгээрийн толоологч буюу омгоологчийн тайлбар, гэрчийн мэдvвлэг, бичмэл ба эд морийн баримт, эсхvл баримт бичиг, шинжээчийн дvгнэлт, кино ба гэрэл зураг, зураглал, дvрс, дууны бичлэг, ул морноос буулгаж авсан хэв, vзлэг, туршилт, таньж олуулах ажиллагааны болон шvvх хуралдааны тэмдэглэл зэрэг нотолгооны хэрэгслээр тогтоогдоно.

35. Захиргааны хэргийг нотлох vургийг хэн хvлээх вэ?

Захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бvхий нотлох баримтыг цуглуулах, vнэлэх vургийг захиргааны хэргийн шvvх гvйцэтгэнэ. Захиргааны хэргийн шvvх хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бvхий нотлох баримтыг байгууллага, албан тушаалтан, иргэнээс гаргаж огохийг шаардах эрхтэй богоод холбогдох этгээд уг шаардлагыг биелvлэх vврэгтэй богоод энэ шаардлагыг биелvллээгvй гэм буруутай этгээдэд Захиргааны хариуцлагын тухай хуульд заасан хариуцлага хvлээлгэнэ. Оролцогч, тvvний омгоологч, толоологч нотлох баримт гаргаж огох, vнэлэхийг захиргааны хэргийн шvvхээс шаардах эрхтэй. Торийн байгууллага, хуулийн этгээд, хувь хvний гаргаж огсон бичмэл нотлох баримтыг уг хэргийн талаар захиргааны хэргийн шvvхээс гаргасан шийдвэр хvчин тоголдор болсны дараа анх гаргаж огсон этгээдийн хvсэлтээр буцааж огч болох богоод шаардлагатай гэж vзвэл хуулбарыг хэрэгт хавсаргана.

36. Нотлох баримт гаргах, цуглуулах талаар хуульд заасан журмыг зөрчиж олж авсан нотлох баримтын vр дагавар нь юу вэ?

Нотлох баримт гаргах, цуглуулах талаар хуульд заасан журмыг зорчиж олж авсан нотлох баримт нотлох чадвараа алдах бoгoод захиргааны хэргийн шvvхийн шийдвэрийн vндэслэл болохгvй. Захиргааны хэргийн шvvх хэрэгт хамааралгvй, нотолгооны ач холбогдолгvй, хуулиар зовшоорогдоогvй баримтыг хэргийн нотлох баримтаас хасах бoгoод тийм баримтыг шаардан гаргуулж болохгvй.

37. Захиргааны хэргийн шvvхэд нэхэмжлэлийг хэрхэн гаргах, нэхэмжлэлийн хэлбэр ямар байх вэ?

Нэхэмжлэлийг хариуцагчийн оршин байгаа газрын захиргааны хэргийн шvvхэд бичгээр гаргах бoгoод нэхэмжлэгч, эсхvл тvvнийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд толоолж буй этгээд гарын vсэг зурсан байна. Монгол Улсын Засгийн газрын гишvvн болон Монгол Улсын яамны эсрэг нэхэмжлэл гаргаж буй тохиолдолд нэхэмжлэлийг Улсын дээд шvvхийн захиргааны хэргийн танхимд гаргана.

38. Захиргааны хэргийн шvvхэд гаргаж буй нэхэмжлэлийн бvрдvvlбэр гэж юу вэ?

Нэхэмжлэлд:

1.нэхэмжлэлийг захиргааны хэргийн ямар шvvхэд гаргаж байгаа;
2.нэхэмжлэгч, хариуцагчийн овог, эцгийн болон оорийн нэр, оршин суугаа газрын хаяг, хуулийн этгээд бол оноосон нэр, оршин байгаа газрын хаяг;

3.нэхэмжлэлийн шаардлагын агуулга;

4.хавсаргасан баримт бичгийн жагсаалтыг тусгах бoгoод vvнийг нэхэмжлэлийн бvрдvvlбэр гэнэ.

Нэхэмжлэлийг толоологч гаргасан бол итгэмжлэл буюу гэрээг хавсаргана. Нэхэмжлэлд нэхэмжлэгч, эсхvл толоологч гарын vсэг зурж, нэхэмжлэл болон тvvнд хавсаргасан баримт бичгийг хариуцагчийн тоогоор хувилж огно.

39. Захиргааны хэргийн шvvхэд гаргаж буй нэхэмжлэлийн агуулга нь ямар байх ёстой вэ?

Нэхэмжлэлийн шаардлагын агуулга гэдэгт:

1.захиргааны байгууллагаас гаргасан захиргааны акт нь иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зорчсонийг нотолж чадах бол тухайн актыг хvчингvй болгуулах;

2.захиргааны байгууллагаас гаргасан захиргааны акт илт хууль бус гэдгийг хvлээн зовшоорvvlлэх;

3.маргаан бvхий захиргааны акт нэхэмжлэгчийн ямар эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зорчсон болон тvvнээс vvdэн гарах хохирлын тухай;

4.захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус эс вйлдэхвй нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хэрхэн зорчсон, тvvний vр дагаврыг арилгах тухай зааж, зорчигдсон эрхээ хэрхэн сэргээлгэхийг хvсч байгаа зэрэг шаардлагыг хамруулан vзэж болно.

Нэхэмжлэлийн шаардлагын агуулга нь дээр дурдсан 4 зvйлийн аль нэг байна.

40. Захиргааны хэргийн шvvх нэхэмжлэл хэрхэн хвлээн авах вэ?

